



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/321

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана-2024” олон улсын XV их наадмын Буриад бөхийн барилдааныг зохион байгуулах зардлыг хавсралтын дагуу баталсугай.

2. Дээрх шаардагдах 55,800,600 (тавин таван сая найман зуун мянга зургаан зуу) төгрөгийг Булган аймаг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2024 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Байгаль хамгаалах зорилгоор байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010887